

БУХА СУЖИГАЙ ГЭДЭГ ГАЗРЫН ТУХАЙ*Л. Оюунгэрэл**

Евразийн байлдан дагуулалтын (1219-1224) дараа Чингис хаан ямар замаар нутаг буцсан тухай асуултанд бүрэн хариулт өгөөгүй байгаа билээ. Нутгийн ойролцоо орших Буха Сужигай гэдэг газарт чулуун дээр бичээс сийлсэн нь (Чингисийн чулууны бичээс гэж нэрлэдэг) худам монгол үсгээр бичиж үлдээсэн анхны бичгийн дурсгал гэж эрдэмтэд тэмдэглэдэг. Дэлхийн олон монгол судлаач тэдний дотор Монголын эрдэмтэн Х.Пэрлээ уг бичээсийг тайлжээ. Чингисийн чулууны бичээс “Чингис ханыг Сартуул иргэ даулж бууж Хамаг Монгол ноёдыг Буха Сужигай хурисанд Есүнгэ онтудрун гурван зууд гучин таван алдаст онтуудлаа” хэмээсэн ажээ.¹

1224 оны өвөл Чингис хаан цэргүүдийнхээ хамт Борохоро ба Ирэн Шабирган уулын Талки буюу Төмөр Хаалга даваагаар давж нутгийн зүг хөдөлжээ. Чухам хаашаа явсан талаар Монголын нууц товчоонд байдаггүй ба харин Алтан товч-д: “...Удар даваагаар давж Хар Зайр нэрт газар хүрэв....Тэндээс хөдлөөд тахиа жилийн намар Туулын хар шугуйд ордонд буув”² гэсэн боловч Буха Сужигай гэдэг газрын тухай огт дурьдаагүй ажээ. Рашид-Ал-Дин бичихдээ: “Хуучин найманы нутагт, уйгурын нутгийн ойролцоо Хилэ голын нөгөө эрэгт Имил-Кучин гэдэг газар хүрч” гээд цаашаа явж “Бука-Су-Джик” гэдэг газар очсон тухай бичжээ.³ Тэнд алтан ордоо барьж (олон зуун хүний багтаамжтай, бас босгыг нь алтадсан), хурал хийж (хуралтай гээгүй байгаа), наадам болжээ. Чухам энэ үеэр чулуун хөшөөн дээр сийлсэнээр Хасарын хүү Есүнгэ 335 алд газар харван онуулж, дээд амжилт тогтоожээ. Олон өдөр ан агнасан тухай эх сурвалжуудад дурьддаг. Чухам хэдэн цэрэг, нийт хэдэн хүн, адуу мал байсан тухай нэгдсэн мэдээ байдаггүй. Гэхдээ олон мянган хүн, мал байсан нь тодорхой. Зөвхөн Самаркандаас гэхэд 30 мянган гар урчуудыг олзолж нутаг руу аваачсан тухай бичдэг.

Чингис хааны цэргүүдийн буцсан тухай А. Амар бичихдээ: “63 оны зун хэрд хуучин Найманы хязгаар дээр Толуйн хөвгүүн Хубилай, Хулагу нар угтаараа одсон ба 64 оны намар Чингис хаан Туул голын Хар Түнэ (шугуй)-ийн ордонд ирж буув” гэжээ.⁴

*Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Харин эдгээр газар, усны нэрийг эх сурвалжууд, П.Карпини, Г.Рубрукийн аян замын тэмдэглэл, мөн Төв Азийн газар усны нэрийг нарийвчлан судалсан Б.Бартольдын “Географический очерк Мавераннахра”⁵ зэрэг номонд байгаа мэдээлэлтэй харьцуулахад Рашид-Ал-Дины дурьдсан “Имил-Кучин” ба “Бука-Су-Джик” гэсэн нэр бол хоёр биш, дөрвөн газрын нэр гэж үзэж болохоор байна. Үүнд: Хилэ гол дээр (Ил) Эмиль буюу Имил нь Алмалык хот ажээ. (одоогийн Кульджа). Харин Кучин - эртний хот Куча байна. (одоогийн Бишбалькийн ойролцоо)

“Бука Сужигай” ч бас дээрх бичлэгтэй нэгэн адил хоёр өөр газрын нэр байж магадгүй гэж үзэн нягтлахад Имил-Кучинээс холгүй, зам дагуу, бас Чингис хааны байлдан дагуулалтын түүхэнд холбогдолтой, ойролцоо орших газрын нэр бол Монголын нууц товчооны 198-р зүйлд гардаг “Бухтарма” ажээ. Нууц товчоонд: Чингис хаан 1205 онд “Алтайн өвөр өвөлжиж” (МНТ-ны франц орчуулганд Улаан Даваа гэж тодруулсан) Эрчис мөрнөөс эх авдаг Бухтарма голын эрэг дээр очиход Найманы Хүчүлэг, Мэргидийн Тогтоа бэхи нарын цэрэг зогсож байсан тухай өгүүлдэг. Бухтарма-г МНТ-ны франц орчуулгын тайлбарт “Buqtarma- Одоогийн Казахстаны нутагт Зайсан нуурын зүүн хойд хэсэгт орших Ирчис мөрөнд цутгадаг гол” гэж тодотгожээ. Ойролцоо орших одоогийн хот бол Алтайск юм.⁶ Ийнхүү байрлал, Чингис хааны цэргүүдийн явсан байж болзошгүй замтай таарч байгаа учраас Рашид-Ал-Дины судрын чуулганд гардаг “Бука” гэдэг нь Бухтарма голын эрэг хавийн нутгийг хэлсэн гэж үзэх үндэстэй.

Тэгвэл “Сужигай” гэдэг нэрийг авч үзье. Монголын нууц товчооны 158, 177-р зүйлд “Сохог усунa” гэж гардаг; “Чингис хаан, Ван хаан хоёр Найманы ...Улуг-Таг-ын Сохог усунa хүрч..” гэжээ. МНТ-ны франц орчуулганд үүнийг “Мест гол” (Glaciale) гэж орчуулаад “Соооq-тюрк нэр” гэж тайлбарлажээ.⁷ Тэгвэл францын эрдэмтэн Р.Груссэ Чингис хааны тухай бичсэн номондоо хавсаргасан газрын зураг дээр Улаан давааны ойролцоох Ховд голыг Согок (Soghoq-тюрк үг) гэж бас тайлбарлажээ.⁸ Ийнхүү бидний эрж байгаа “Сужигай” гэдэг нэр Ховд гол буюу “Сохог” усунтай дуудлагын хувьд ойролцоо, бас хамгийн чухал нь газар зүйн байршлын хувьд тохирч байгаа юм. Иймээс Бука Сужигай гэдэг нь тодорхой нэг газрын оноосон нэр биш харин Бухтарма гол-Улаан даваа-Сохог усун-ы хоорондох оройн зайг нэрлэсэн гэж таамаглаж болно. Тал хөндий, ой мод, уул, ус бүхий энэ орон зайн хоёр зах: Бухтарма - Сохог ажээ.

Харин Чингис хааны явсан зам нь Бухтарма голын эрэг орчим - Улаан Даваан-Сохог усун (Ховд гол) - Богосог уул байна. Хожим 1869 онд Ховдын зүүн хойд хэсэг дэх Сийлхэм уулын дунд хэсэгт орших Богосог даваан дээр хилийн тэмдэг тавьж байжээ.⁹ Богосог даваанаас одоогийн Улиастайгаар дамжин Хархорум-д очиход нэн дөт байсан бололтой. (Чингис хаан Хархорум хотыг байгуулах тухай Хорезмын аян дайны үеэр ярьж байсан ба дайнд ялагдсан улс орнуудаас тийшээ ачаа бараа зөөдөг байжээ.)

Ийнхүү Буха Сужигай хэмээх газар сийлсэн Чингисийн чулуун хөшөө нь Хорезмын булюу Евразийн аян дайны ялалтыг бэлгэдсэн хөшөө байсан төдийгүй, гурван хөвгүүнийх нь хувь газруудын хил заагийг тогтоосон газар байжээ. Энэ газар өнөөдөр ч Монголын хилийн ойролцоо байгаа Орос, Хятад, Казахстанд нэн дөт стратегийн байрлал мөн байна.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Х. Пэрлээ, Гурван өгүүлэл, УБ, 1962, х. 23
2. Лувсанданзан, Алтан товч, УБ, 1990, х. 136
3. Рашид-Ад-Дин, сборник летописей, М., 1952, том 1, х. 230
4. А. Амар, Монголын товч түүх, х. 153
5. Б. Бартольд, Сочинения, М., 1963, том 1
6. Histoire Secrete des Mongols, Chronique Mongole du XIII siecle, traduit et annote par Marie-Dominique Even et Rodica Pop, Gallimard, 1994, p. 288
7. мөн тэнд, х. 280
8. R. Grousset, Le Conquerant du Monde, Vie de Gengis-khan, ed. Albin Michel, Paris, 1944. (хавсралт газрын зураг)
9. Орос-Хятадын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхэтгэл, 1-р хэсэг, УБ, 2001, х. 63